# ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.......4

Төслийн ерөнхий мэдээлэл ....................................................................4

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....................................................................6

4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....................................................................16

5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ...................17

6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ..........................20

7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....................................................................24

8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....................................................................26

9. ДҮГНЭЛТ ....................................................................27

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000011404 дугаартай 7.9819 га газрын булангийн цэгүүд ....4
Хүснэгт 2. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ....6
Хүснэгт 3. Төслийн орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт ....14
Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ....16
Хүснэгт 5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ....17
Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт ....20
Хүснэгт 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ....24
Хүснэгт 8. Хустайн БЦГ, орчны бүсийн 3 сумтай хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд ....24
Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт ....26

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг ....5
Зураг 2. Жуулчны баазын гэр хоорондын явган хүний зам ....10
Зураг 3. Баазын ариун цэврийн өрөө ....12
Зураг 4. Хаврын мод тариалалтын үеийн зураг....14
Зураг 5. Зэрлэг ургамлын цэвэрлэгээ....15
Зураг 6. Хустай аялал жуулчлалын баазын хог хаягдлын менежмент....18
Зураг 7. Хогны төлбөр төлсөн баримт....19

# 1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн ерөнхий мэдээлэл**

***Төслийн нэр*** - “Хустайн” аялал жуулчлалын баазын төсөл

***Төсөл хэрэгжүүлэгчийн нэр***
- “Хустайн цогцолбор газар төв” НҮТББ
- Улсын бүртгэлийн дугаар: 9071044112
- Регистрийн дугаар: 1030914

***Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас***
- Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 2-р хороо, 2-р хороолол, Хустайн төвийн байр Утас: 99188884

***Компанийн хэлбэр***
- Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага

***Төслийн зорилго:***
- Хустайн байгалийн цогцолборт газрын хилийн гадна орших байгалийн сайхан нутагт үйлчилгээний олон улсын чанар, стандартад нийцсэн тохилог, орчин үеийн аялал жуулчлалын байнгын үйлчилгээтэй ”Хустай жуулчны бааз”-аар гадаад, дотоодын амрагч, жуулчдад үйлчлэх, ингэснээр орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, мөн дэлхийд нэн ховордсон зэрлэг амьтан-тахь адууг сэргээн нутагшуулж буй Хустайн байгалийн цогцолборт газрыг хамгаалан сурталчлах зэрэг үйл ажиллагаа явуулах

***Харьяалал***
- Монгол

***<u>Төслийн байршил:</u>***

Төв аймгийн Аргалант сумын 2-р баг Тариатын давааны ард хэмээх газарт байрлана. Улаанбаатар хотоос баруун урагш 100 км, Хустайн БЦГ-аас 0.4 км зайд, Аргалант сумын төвөөс урд зүгт 22.0 км зайд байрлана.

- Талбайн хэмжээ: 27.9 га
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L48-8

***<u>Газарзүйн солбицол</u>***

*Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000011404 дугаартай 7.9819 га газрын булангийн цэгүүд*

| № | | Уртраг | | | Өргөрөг | |
|---|---|---|---|---|---|---|
| | градус | минут | секунд | градус | минут | секунд |
| 1 | 105 | 52 | 31.4 | 47 | 45 | 50.7 |
| 2 | 105 | 52 | 31 | 47 | 46 | 4.6 |
| 3 | 105 | 52 | 48.3 | 47 | 46 | 4.7 |
| 4 | 105 | 53 | 0.5 | 47 | 46 | 3.4 |
| 5 | 105 | 52 | 52.7 | 47 | 45 | 47.2 |
| 6 | 105 | 52 | 36.1 | 47 | 45 | 47 |




*Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг*

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 2. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | **2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт** | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | |
| 1 | Агаарын бохирдол үүсэх | Ил задгай хог хаягдал шатаахгүй байх | Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг төслийн талбайд байрлах хог хаягдлын түр цэгт цуглуулан, гэрээний дагуу зайлуулдаг. | Дотоод зардал | |
| 2 | | Орчны тоосжилт үүсгэхгүй байхад анхаарч, ил гарсан элэгдэлд орсон хөрсийг зүлэгжүүлэх | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зүлэгжүүлэлт хийж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн. | Үйл ажиллагааны зардал | |
| 3 | | Аялал жуулчлалын баазын үйл ажиллагаанд хэрэглэгдэх тээврийн хэрэгслийг тогтмол үзлэг оношилгоонд хамруулж, засвар үйлчилгээг тухай бүр хийж байх | Хустай байгалийн цогцолборт газрын үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг оношилгоонд хамруулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| 4 | | Ашиглаагүй үед техник, төхөөрөмжийг даруй унтрааж байх. Хөдөлгүүрийг 5 минутаас илүү сул асаахгүй байх, олон салаа зам үүсгэхгүй нэг замаар зорчих, зориулалтын зогсоолд байршуулахыг анхааруулсан анхааруулга санамжийг мэдээллийн самбарт тавих | Авто зогсоолын тэмдэг байршуулж, ажилчид болон амрагчдад олон салаа зам гаргаж зорчихгүй байхыг анхааруулга болгон ажилладаг. | Үйл ажиллагааны зардал | |
| Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | |
| 5 | Усан орчин бохирдох,<br><br>Усны нөөц хомсдох | Ногоон байгууламжийн усалгаанд ашиглахаар борооны ус цуглуулах, нөөцлөх бичил байгууламжтай болох | Борооны усыг хуримтлуулан ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж байна. | Үйл ажиллагааны зардал | |
| 6 | | Ус бохирдуулсны төлбөр төлөх | Ус бохирдуулсны төлбөрийг төлсөн. | Үйл ажиллагааны зардал | |
| 7 | | Ус хэмнэх технологи хэрэгжүүлэх /ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулах/ | Ариун цэврийн байгууламжийг сайжруулан, ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| 8 | | Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах | Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллаж байна. | Үйл ажиллагааны зардал | |
| 9 | | Ус ашиглагч нь бохирын цэгийн эзлэхүүний 70-80 хувь дүүрсэн үед суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ. | Бохир ус зайлуулах цооногийг тухай бүр суллаж, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэж байсан. | Үйл ажиллагааны зардал | |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | **2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт** | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | |
| 10 | Хөрсний бохирдол | Төслийг хэрэгжүүлэх явцад төслийн талбай болон түүний ойр орчимд олон салаа зам гаргаж, хөрсийг элэгдэл эвдрэлд оруулах, бохирдуулахаас урьдчилан сэргийлж, зам талбайн тэмдэгжүүлэлтийг зохих дүрэм журмын дагуу хийж, хаалт хамгаалалт хийх | Төслийн талбай болон түүний ойр орчимд ажилчид болон амрагчдад зориулан зам талбайн тэмдгийг байршуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| 11 | | Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах | Гадна талбайн цэвэрлэгээ үйлчилгээ тогтмол хийж, орчны тохижилтыг сайжруулан, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. | Үйл ажиллагааны зардал | |
| 12 | | Зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх | Төслийн талбайн хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт хаяж гэрээний дагуу тогтмол зайлуулж байсан. | Үйл ажиллагааны зардал | |
| 13 | | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хаягдлыг дахин боловсруулдаг байгууллагуудад хүлээлгэн өгч, хамтран ажиллах | Төслийн үйл ажиллагаанаас гарсан дахин боловсруулах дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахин боловсруулдаг байгууллагатай хамтран ажиллахаар судалж байна. | Үйл ажиллагааны зардал | |
| 14 | | Төслийн хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах | Төслийн хог хаягдлыг орон нутагтай хийсэн гэрээний дагуу тогтмол зайлуулдаг. | | |
| 15 | | Төв замаас тухайн эдэлбэр газар хүртэл нэг замтай байх ба замын дагуу (500-1000) м-ийн зайд MNS 4596:2014, Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм стандартын дагуу цогцолбор хаяг бүхий замын тэмдгийг байршуулах. | Төв замаас төслийн талбай хүртэлх замын дагуу тэмдэг тэмдэглэгээг байршуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| **Нийт дүн** | | | | - | - |

***Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ***

Хустай БЦГ-ын авто тээврийн хэрэгслүүдийг төлөвлөгөөт хугацаанд үзлэг оношилгоонд оруулсан.

**1- Toyota Land cruiser**




**2- УАЗ 220695**




**3- ISUZU ELF**



**4- УАЗ 220695**




**5- Toyota Land cruiser**




**6- Toyota Land cruiser**



**7- Toyota Land cruiser**




***Газрын гадарга, хөрсөн орчныг хамгаалах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ***



*Зураг  1. Төслийн талбайн барилга байгууламж*



*Зураг 2. Жуулчны баазын гэр хоорондын явган хүний зам*

Жуулчны баазын амрагчдын гэрүүдийн хоорондох явган хүний зам, авто зогсоол болон бусад тэмдэг, тэмдэглэгээг байнга сэргээн засварлаж байршуулсан.










***Усан орчин бохирдох, усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ***

Ариун цэврийн өрөөнүүдэд мэдрэгчтэй угаалтуурын холигч, хос даралтат суултуур зэрэг ус хэмнэх сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулсан, мөн ариун цэврийн өрөөнүүд агааржуулагч сэнстэй.




*Зураг 3. Баазын ариун цэврийн өрөө*

Цэвэрлэх байгууламжид өргөтгөл хийж, эвдэрч гэмтсэн шугам хоолойг засварлаж ажилласан.



*Зураг 4. Цэвэрлэх байгууламжийн зураг*

## 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 3. Төслийн орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт*

| № | 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | **2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт** | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Ногоон байгууламж бий болгох<br>Хөрс бэлтгэх<br>Нүх бэлтгэх | Жил бүр 500- 600 мод тарьдаг бөгөөд 2023 онд хайлаас-350 ш, улиас- 250 ш тарьсан. | 4,600,000 | |

Хустай БЦГ нь жил бүр Аргалант сумын "Аргалын ногоон төгөл хоршоо" мод үржүүлгийн газартай хамтран ажилладаг. 2023 онд тус хоршоотой хамтран баазын талбайд нийт 600 ширхэг мод суулгасан. Үүнд: улиас-250ш, хайлаас -350 ш тарьсан. Ногоон байгууламж бий болгох ажлын хүрээнд 4.6 сая төгрөг зарцуулсан.



*Зураг 5. Хаврын мод тариалалтын үеийн зураг*

Жуулчны баазын тойрны зэрлэг ургамал, халгай зэргийг байнга тайрч цэвэрлэсэн.



*Зураг 6. Зэрлэг ургамлын  цэвэрлэгээ*

# 4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | **2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт** | Нийт зардал |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Археологийн болон Палеонтологийн дурсгал | Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой. | Төслийн талбайд соёлын биет өв илрээгүй болно. | - |
| **Нийт дүн** | | | | - |

# 5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Хог хаягдлын ангилал | 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн ажил | **2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт** | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | | |
| 1 | Ахуйн хог хаягдал | Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах | Хог хаягдлын цэгийг ангилах ялгах байдлаар тохижуулан ажиллаж байна. | Үйл ажиллагааны зардал | |
| | | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэрэгт 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх. Төслийн талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах | Хог хаягдлыг ангилан ялгаж хаях хогийн савыг амрагчдын байранд болон ажилчдын байр, гадаа талбайд байрлуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| | | Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийг “MNS 5161-3:2002, Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлд. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ стандартын дагуу мэргэжлийн газраар гүйцэтгүүлэх. | Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийг стандартын дагуу мэргэжлийн газраар хийлгэсэн. | Үйл ажиллагааны зардал | |
| | | Хог хаягдлыг зориулалтын цэгээс нэгдсэн хогийн цэгт тээвэрлэхэд MNS 5344:2003, Ахуйн хог хаягдал тээвэрлэлт ангилал. Ерөнхий шаардлага” стандартыг баримтлах. | MNS 5344:2003, Ахуйн хог хаягдал тээвэрлэлт ангилал. Ерөнхий шаардлага” стандартыг баримтлан ажилладаг. | Үйл ажиллагааны зардал | |
| | | Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах, орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хог устгалын цэгт хүргэх | Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулж, орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хог устгалын цэгт хүргүүлж устгуулдаг. | Үйл ажиллагааны зардал | |
| | | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэрэгт 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх. | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаан 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. | Үйл ажиллагааны зардал | |
| **Нийт дүн** | | | | | - |

***Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ***

Хог хаягдлын нэгдсэн цэгийг засварлаж, ангилан ялгах савыг өөрсдөө хийж байршуулав. Мөн бид хог менежментийг сайжруулан дахин боловсруулах, дахин ашиглах боломжтой хуванцар сав, шил, лааз зэрэг хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгалт хийж Аргалант сумын хоёрдогч түүхий эд авах цэгт хүргэж өгдөг болоод байна. Цаашид бид хог хаягдлыг илүү олон төрлөөр ангилж хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашигладаг компануудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна.




*Зураг 7. Хустай аялал жуулчлалын баазын хог хаягдлын менежмент*

**Худалдаа Хөгжлийн Банк**

Огноо: **2023.11.02 09:30:53**

**Шилжүүлгийн мэдээлэл**

Журналын №: **118055365**

Системийн огноо: **2023.08.31**

Нэр: **ХУСТАЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР ТӨВ**

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Илгээгч** | Дансны дугаар: **405002328** | Нэр **ХУСТАЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР ТӨВ** | Дүн **120,000.00 MNT** | Ханш **1.00** |
| | | **/ нэг зуун хорин мянган төгрөг /** | | |
| **Хүлээн авагч** | Банкны дугаар: **04** Дансны дугаар | Банкны нэр **Худалдаа Хөгжлийн Банк** Нэр | **120,000.00 MNT** | **1.00** |

Гүйлгээний утга:
**ЕВ -2230802314022-Хог хаягдлын үйлчилгээний хураамж-Төв**

**Танд баярлалаа**

**Гүйлгээний баримтыг баталгаажуулсан**
Салбар, тооцооны төв:
Гарын үсэг:

*Зураг 8. Хогны төлбөр төлсөн баримт*

# 6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

*Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт*

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэг байршил | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Хөрсөн бүрхэвч | | | | | |
| 1 | - Хөрсний агрохими | - Хөрсний ерөнхий төлөвийг төлөөлж чадахуйц-1 цэг | Хөрсний агрохими, хүнд металлын дээжийг 200-300 гр хэмжээтэй авч “Нарт Шуун Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав). | 25,000.0 | 25,000.0 |
| Усны чанар | | | | | |
| 3 | Усны чанарын үндсэн үзүүлэлт | - Гүний худгийн ус-1 цэг<br>- | Унд, ахуйн хэрэглээний уснаас нэг усны сорьц авч Цаг уур орчны шинжилгээний газар Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав). | 45,000.0 | 45,000.0 |
| 4 | Усны чанарын үндсэн үзүүлэлт | - Цэвэрлэх байгууламжийн гаралтын ус-1 цэг | Унд, ахуйн хэрэглээний худгийн уснаас усны сорьц авч Цаг уур, орчны газар Байгаль орчны хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав). | 45,000.0 | 45,000.0 |
| **Нийт дүн** | | | | | **115,000.0** |

Хустай баазын ундны усны шинжилгээний хариу

MNAS Accreditation system

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН**
**ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

БАЙГАЛЬ

**СОРИЛТЫН ДҮН**

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2023/ Ц-67 |
| Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : Хустайн Цогцолбор Газар |
| Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал | : Л.Цэдэнхүү |
| Сорьцын тоо,төрөл | : 1, ус |
| Сорьцыг авсан огноо | : 2023.05.17 |
| Сорьцын тодорхойлолт | : Усны сорьц |
| Шинжилгээний аргын стандарт | **MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999, MNS 6271:2011, MNS 4424:2005 MNS 1097:1970, MNS 6832:2020** |
| Шинжилсэн огноо | : 2023.05.17-2023.05.31 |
| Хуудасны тоо | : 2 /2 |
| Үр дүн | : 1 |

| Сорьцын нэр | pH | EC мкСи/см | $SO_4$ мг/л | Cl мг/л | Ca мг/л | Mg мг/л | Na+K мг/л | $HCO_3$ мг/л | Эрд мг/л | Хат мг-экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төв аймаг Аргалант сум Хустайн нуруу жуулчны бааз Ундны ус | 8.06 | 365 | 40.8 | 10.6 | 38.9 | 16.6 | 41 | 232 | 339 | 3.31 |
| **MNS 0900:2018** | **6.5-8.5** | **1000** | **500** | **350** | **100** | **30** | **-** | **-** | **-** | **7.0** |

Тайлбар: EC - цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэсжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер: Б.Жавзандулам
Шалгасан инженер: С.Отгонжаргал
Хянаж баталгаажуулсан инженер: Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

MNAS Accreditation system

БАЙГАЛЬ
ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

## СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2023/ Ц-67 |
| Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : Хустайн Цогцолбор Газар |
| Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал | : Л.Цэдэнхүү |
| Сорьцын тоо,төрөл | : 1, ус |
| Сорьцыг авсан огноо | : 2023.05.17 |
| Сорьцын тодорхойлолт | : Усны сорьц |
| Шинжилгээний аргын стандарт | **MNS ISO 6836:2020, MNS ISO 8467:1999**<br>**MNS ISO 7150-1:2006, MNS 4431:2005**<br>**MNS 7890-3:2001, MNS ISO 6878:2001**<br>**MNS 4430:2005, MNS 6272: 2011** |
| Шинжилсэн огноо | : 2023.05.17-2023.05.31 |
| Хуудасны тоо | : 1 /2 |
| Үр дүн | : 1 |

| Сорьцын нэр | Ж/б мг/л | ПИЧ мг/л | $NH_4$ мгN/л | $NO_2$ мгN/л | $NO_3$ мгN/л | $PO_4$ мгP/л | Fe мг/л | F мг/л |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төв аймаг Аргалант сум Хустайн нуруу жуулчны бааз Ундны ус | 1.4 | илр | илр | 0.033 | 17.32 | 0.002 | 0.04 | 0.89 |
| **MNS 0900:2018** | - | - | **1.5** | **1.0** | **50** | **3.5** | **0.3** | **0.7-1.5** |

Тайлбар: Ж/б- Жинлэгдэгч бодис, ПИЧ-Перманганатын Исэлдэх Чанар, Илр- Илрээгүй

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер: Б.Жавзандулам
Шалгасан инженер: С.Отгонжаргал
Хянаж баталгаажуулсан инженер: Б.Алтантуяа

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Хустай баазын цэвэрлэх байгууламжийн гаралтын усны шинжилгээний хариу

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН**
**ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

**СОРИЛТЫН ДҮН**

| | | |
|---|---|---|
| Дугаар он/№ | : | 2023 / Б-53 |
| Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : | Хустайн цогцолбор газар |
| Сорьцыг авсан хүний нэр,албан тушаал | : | Л.Цэдэнхүү, 99844462 |
| Сорьцын тоо,төрөл | : | 1, бохир ус |
| Сорьцыг авсан огноо | : | 2023.05.17 |
| Сорьцын тодорхойлолт | : | Бохир усны сорьц |
| Шинжилгээний аргын стандарт | : | **MNS ISO 10523:2001, MNS 6836 :2020**<br>**MNS ISO 8467:1999, MNS ISO 5815-1:2015**<br>**MNS ISO 7150-1:2006, MNS 4431:2005**<br>**MNS ISO 7890-3:2001, MNS ISO 6878:2001** |
| Шинжилсэн огноо | : | 2023.05.17-2023.05.31 |
| Хуудасны тоо | : | 1 /1 |
| Үр дүн | : | 1 |

| Сорьцын авсан цэг | pH | Ж/б мг/л | ПИЧ мг/л | $БХХ_5$ мг/л | $NH_4.N$ мг/л | $NO_2.N$ мг/л | $NO_3.N$ мг/л | $N_{нийт}$ мг/л | $P_{эрд}$ мг/л |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төв аймаг Аргалант сум Хустайн нуруу жуулчны бааз Цэвэрлэх байгууламжаас гарсан саарал ус | 7.57 | 6.4 | 20.0 | 11.3 | 9.95 | 0.610 | 8.30 | 18.86 | 5.880 |
| **MNS 4943:2015** | **6-9** | **30** | **20** | **20** | **-** | **-** | **-** | **15** | **1.5** |

Тайлбар: Ж/б- Жинлэгдэгч бодис, ПИЧ-Перманганатын Исэлдэх Чанар, $БХХ_5$- Биохимийн Хэрэгцээт Хүчилтөрөгч

Шинжилгээ хийсэн инженер: Б.Жавзандулам

Шалгасан инженер: Ц.Мийдүв

Хянаж баталгаажуулсан инженер: С.Отгонжаргал

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ ҮИТ0235

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно

# 7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт*

| № | 2023 онд хэрэгжүүлэх БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төлөвлөсөн ажлууд | **2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт** |
|---|---|---|
| 1 | Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх | Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж ажиллаж байна. |
| 2 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг БОАЖЯ-нд хүргүүлж байх, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх | БОМТ болон биелэлтийн тайланг хариуцах мэргэжилтэн томилж, хуульд заасан хугацаанд өгч ажиллаж байна. |
| 3 | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа мэргэжлийн байгууллагаар төлөвлөгөөт хугацаанд хийлгэсэн. |
| **Нийт дүн** | | **3,000,000.0** |

***Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагтай хамтран хэрэгжүүлсэн ажлууд***

*Хүснэгт 8. Хустайн БЦГ, орчны бүсийн 3 сумтай хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд*

| № | Хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд | Хугацаа |
|---|---|---|
| **1** | Жил болгон 3 сумтайгаа хамтран "Алтан Тахь" нөхөрсөг спортын арга хэмжээг ээлжлэн зохион байгуулдаг. | 4 сард |
| **2** | Орчны бүсийн 3 сумдын удирдлагуудтай уулзаж ОБХСангийн зээлийг олгосон. Энэ жил нийт 300 сая төгрөгийг 3 сумын 28 иргэнд (ногоон тэжээл болон хүнсний ногоо тариалах, махны чиглэлийн фермер, эсгий эдлэл хийх, хүнсний зоорь барих, саалийн үнээ авах, цагаан идээ боловсруулах зэрэгт) | 5 сард |
| **3** | Аргалант сумтай хамтран засмал зам дагуух 10 км газарт их цэвэрлэгээ хийж 5 тн хогийг Аргалант сумын нэгдсэн хогийн цэг дээр буулгалаа. | 5 сард |
| **4** | Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан "Махны чиглэлийн үхэр, түүний ашиг" сэдэвт чуулганд 3 сумын 8 иргэнийг оролцуулж, туршлага судлууллаа. | 5 сарын 10 |
| **5** | Жил бүр зохион байгуулдаг "Хустай зуслан"-нд 3 сумын 15 хүүхэд хамрагдаж 5 хоногийн хугацаанд "Мойлт бааз" дээр байрлан, манай биологич,судлаач, менежерүүдээр байгаль, экологи, аялал жуулчлалын чиглэлээр хичээл заалгаж намар хичээл орохоор тус үзсэн хичээлүүдээ ЕБС-ийн хүүхдүүдэд тайлагнадаг. | 8 сард |
| **6** | Жил болгон "Хустай" жуулчны бааз 3 сумдынхаа иргэдтэй хамтран "Монгол ахуйн өдөрлөг" арга хэмжээг зохион байгуулдаг. Энэ жил нийт 4 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, зорин ирж буй дотоод, гадаадын иргэдэд монгол ахуйг танилцуулахаас гадна жуулчид өөрсдөө гар бие оролцон цагаан идээ хийх, тоглоом наадгай зэрэг үйл | 7-8 сард |

| | | |
|---|---|---|
| | ажиллагаанд идэвхтэй оролцдог. (малчдын хийсэн гар урлалын зүйлсийг борлуулах, сур элдэх, нум сум харвах, бяслаг хийх, шагайн наадгай, сээр цохих г.м ) | |
| **7** | 3 сумдын багийн өдөрлөгт оролцож Хустайн ЦГТ-ийн талаарх танилцуулга, илтгэл тавилаа. | |
| **8** | .МУЗН-тэй хамтран ажилладаг. Ковид-19 цар тахлын дараа хамтын үйл ажиллагаагаа сэргээн шаардлагатай үед эмнэлгийн анхны тусламжийг хэрхэн зөв үзүүлэх ур чадварыг дадлага ажлын хамт Хустай төв дээрээ зохион байгуулан анхны тусламжийн сургалтад 8 малчин өрхийг хамруулж гэрчилгээ олголоо. | 9 сард |
| **9** | Алтанбулаг сумын ЕБС-ийн ариун цэврийн байгууламжийн засварт 6 сая төгрөгийн мөнгөн тусламж үзүүллээ | |
| **10** | Өвлийн нэг бэрхшээлтэй зүйлийн нэг бол ТХГН- руу малчид адуугаа ихээр оруулдаг. Энэ талаар 3 сумдын удирдлагуудтай биечлэн уулзаж цаашид авч хэрэгжүүлэх арга зам, төлөвлөгөөг хэлэлцлээ. | 10 сард |

# 8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт*

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийг бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|
| 1 | Төв аймгийн БОАЖГ-т БОМТ-ний биелэлтийг тайлагнах | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл хэлбэрээр 2023 оны 11-р сарын 01-ны өдөр хүргүүлсэн. |
| 2 | БОАЖЯ тухайн жилийн БОМТ батлуулах | Тухайн жилийн БОМТ-өөг БОАЖЯ-ны сайтад онлайн хэлбэрээр байршуулсан. |
| **Нийт дүн** | | **-** |

## 9. ДҮГНЭЛТ

Төв аймгийн Аргалант сумын нутагт байрлах “Хустайн цогцолборт газар төв” НҮТББ-ын “Хустай” нэртэй аялал жуулчлалын баазын төслийн 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн үр дүнд бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 – ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу боловсруулав;
- “Хустайн цогцолборт газар төв” НҮТББ нь 2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт 7,835,000.0 төгрөг зарцуулсан байна;